



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.19 оны 06 сарын 06-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 77.5-р зүйлд заасны дагуу Говь хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн З.Шагдарсүрэнгийн гаргасан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг үндэслэн Говь хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Зуунайн Шагдарсүрэнг 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдрөөр Говь хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 77.5-д заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүний нөхөн сонгууль хүртэл Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүний үүргийг түр гүйцэтгэх этгээдийг хууль, дүрэмд нийцүүлэн сонгон шалгаруулж, томилох асуудлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд даалгасугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Д.БАТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН